

Checklist – Schengen or National Visa – Other forms of education or training

Бичиг баримтын жагсаалт – Шенгений болон Үндэсний виз – Бусад төрлийн боловсрол/сургалт

Visa category eligible for applicants travelling to Poland to participate in education/training programmes, including bilateral study exchanges.

Боловсрол/сургалтын хөтөлбөр тэр дундаа хоёр талын солилцооны сургалтад оролцохоор Польш Улсад зорьчиж буй виз хүсэгч энэ ангиллын виз мэдүүлнэ

<p>Name: Нэр: _____</p> <p>Passport number: Паспортын дугаар: _____</p>	<p>Purpose of visit: Аялын зорилго: _____</p> <p>Contact no.: Холбоо барих утасны дугаар: _____</p> <p>E-mail address: И-мэйл хаяг: _____</p>
---	---

Please be informed that failure to submit the documents listed below **may result in refusal decision in your visa case by the Embassy/Consulate General of the Republic of Poland**. The required documents have to be translated into Polish or English in a separate document according to the instructions below. The passport remains at the Embassy/Consulate during the review of the documents.

Та виз мэдүүлэхдээ доор дурьдсан бичиг баримтуудыг бүрдүүлж өгөх шаардлагатай бөгөөд **бүрэн гүйцэд бүрдүүлээгүй тохиолдолд Бүгд Найрамдах Польш Улсын Элчин сайдын яам/Ерөнхий Консулын Газар таны визний мэдүүлгийг хүлээж авахгүй болно**. Виз мэдүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтууд польш эсвэл англи хэл дээр орчуулагдсан байх ёстой бөгөөд бичиг баримтыг доорх дарааллын дагуу цэгцэлж өгнө үү. Визний мэдүүлгийг хянан шийдвэрлэх хугацаанд виз мэдүүлэгч иргэний гадаад паспорт БНПУ-ын Элчин сайдын яам/Ерөнхий Консулын Газарт хадгалагдана.

Note: The application material should be placed in the following order:
Анхаарах зүйл: Та бичиг баримтаа дараахи дарааллын дагуу цэгцэлж өгөх шаардлагатай:

Required documents		Yes	No	Remarks
Виз мэдүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтын жагсаалт		Тийм	Үгүй	Анхаарах зүйл
1.	<p>Visa application form completed in Latin alphabet and signed by the applicant (in case of a minor signed by both parents or legal guardians). <u>One color photograph</u> (white background, 35 mm x 45 mm, not older than 6 months). Бүрэн гүйцэд бөглөсөн, виз хүсэгчийн (насанд хүрээгүй иргэнийг төлөөлөн эцэг, эх хоёулаа эсвэл асран хамгаалагч, харгалзан дэмжигч гарын үсэг зурна) гарын үсэгтэй виз мэдүүлэх хуудас. Виз хүсэгч гарын үсгээ латин үсгээр галиглан бичсэн байна. <u>Нэг хувь өнгөт цээж зураг</u>. Цээж зураг дараахи шаардлагыг хангасан байна. Үүнд: цагаан фонтой, 35mm x 45mm хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан байна.</p>			
2.	<p>Passport or other travel document and one copy of the identification page, copy of the pages with Schengen/Polish national visas (if issued) and copy of page with signature on the passport. If the visas were in the previous passport – copy of that passport identification page and page with signature. Travel document must be: not older than 10 years, valid for at least 90 days after the expiration of visa and containing at least 2 blank pages. Гадаад паспорт эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг хуулбарын хамт. Гадаад паспортын цээж зурагтай, Шенген/Польшийн үндэсний визтэй, виз хүсэгчийн гарын үсэгтэй хуудаснуудын хуулбарыг хавсаргана. Хэрвээ хуучин эзэмшиж байсан паспорт</p>			

	<p>дээр виз тавигдсан байгаа бол цээж зурагтай, виз хүсэгчийн гарын үсэгтэй хуудаснуудын хуулбарыг хавсаргана.</p> <p>Гадаад паспорт дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: паспорт олгосон хугацаанаас хойш 10-аас дээш жил болсон хуучин паспорт байж болохгүй, хүчинтэй хугацаа нь мэдүүлж буй визний дуусах хугацаанаас хойш 90 хоногоос дээш байна, 2-оос доошгүй цэвэр (аливаа тэмдэглэгээ хийгдээгүй, тамга дардас тавигдаагүй) хуудастай байна.</p>			
3.	<p>Original ID with copy Иргэний үнэмлэх хуулбарын хамт</p>			
4.	<p>Original residence permit/other proof of legal stay in Mongolia, with copy (applicable to foreign citizens except Mongolian citizens) valid for at least 3 months after the date of submission of visa application.</p> <p>Монгол Улсад байнга оршин суух зөвшөөрөл/хууль ёсны оршин суух бусад бичиг баримт (Монгол Улсын иргэнээс бусад гадаадын иргэнд хамаарна)-ын эх хувь. Баримт бичиг виз мэдүүлсэн өдрөөс хойш 3 сараас дээш хугацаанд хүчинтэй байх ёстой.</p>			
5.	<p>Travel medical insurance covering the entire duration of stay with a minimum coverage of 30 000 EUR, including costs of emergency medical treatment, repatriation for medical reasons as well as transportation in case of death. Handwritten certificates will not be accepted. The name of the insured should be also written in Latin alphabet.</p> <p>Гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалын эх хувь, хуулбарын хамт. Даатгал нь Шенгений бүсийн бүх гишүүн орнуудад, аяллын бүх хугацаанд үйлчлэх ёстой. Яаралтай эмчилгээ хийлгэх, эрүүл мэндийн шалтгаанаар эх оронд нь авчрах, нас барсан тохиолдолд тээврийн зардлыг нөхөн төлөх, 30.000 Еврогоос дээш үнэлгээтэй даатгалд даатгуулсан болохыг батлах баримт байна. Гараар бичсэн даатгалыг хүлээн авахгүй. Даатгуулагчийн нэрийг мөн латин галигаар бичсэн байна.</p>			
6.	<p>The original certificate of the unit conducting the education/training course confirming the purpose of travelling, covered expenses and duration of education/training, indicating the major, not older than 3 months.</p> <p>Боловсрол/сургалт зохион байгуулагчаас гаргасан албан бичиг. Албан бичигт аяллын зорилго, сургалтын зардал, үргэлжлэх хугацаа, сургалтын чиглэлийг тодорхойлсон байна. Сургалт, дамжаа нь 3 сараас дээшгүй хугацаанд үргэлжлэхээр байна.</p>			
7.	<p>Proof of payment for studies or proof of receiving a scholarship (if applicable) – issued by the unit conducting the studies.</p> <p>Сургалтын төлбөрөө төлсөнийг батлах баримт, хэрвээ тэтгэлэг авсан бол түүнийг нотлох баримт (хэрвээ энэ асуудал тантай холбоотой бол). Эдгээр баримтыг сургалт зохион байгуулагчаас гаргуулан авсан байна.</p>			
8.	<p>Original letter from the University/school/organization in Mongolia (with the information about the purpose of travelling, covered expenses and duration of education) confirming student’s status. Student’s ID card (if applicable)</p> <p>Одоо Монголд суралцаж буй сургууль, ажиллаж байгаа газраас гаргасан албан бичиг. Албан бичигт аяллын зорилго, сургалтын төлбөрийг төлсөн болон тэтгэлэг авсан тухай, сургалтын үргэлжлэх хугацаа зэрэг мэдээлэл агуулсан байх ба оюутны статусыг баталгаажуулсан байна. Оюутны үнэмлэх (хэрвээ энэ тантай холбоотой бол) хавсаргана.</p>			

<p>Proof of financial means (one of the following documents):</p> <ol style="list-style-type: none"> 1. Traveler's cheque, 2. Certificate of the amount of the credit card limit issued by the bank (any bank located in Mongolia or Poland or another country is allowed), 3. Certificate of availability of money in a Polish or European Union bank or a cooperative savings and loan association located in the territory of the Republic of Poland or European Union (certificates of Mongolian banks are not accepted), 4. Document confirming the grant of a national or foreign scholarship, 5. Certificate of employment with monthly salary statement. <p>Documents stated in point 2,3 and 5 shall not be issued more than one month before submission of visa application.</p> <p>Minors and adults financially dependent on their parents (if applicable) Notarized sponsor's letter from parents, as well as documents confirming the availability of financial resources (points 1-5). The letter should state that parents are required to cover all travel and accommodation expenses of the applicant. If the applicant's parents are not indicated in the applicant's birth certificate, the applicant must submit a notarial certificate on family ties in Mongolian with a translation into Polish or English, legalized by the MFA.</p> <p>Sponsorship by a third person is possible only after obtaining approval from the consul – the sponsor's letter must be certified by a notary and legalized by Mongolian MFA.</p> <p>Supplementary materials:</p> <ul style="list-style-type: none"> • Certificates from parents' workplaces, duly signed and stamped, with a specification of monthly remuneration. <p>9. • If the parents are retired, proof of retirement or other regular income is required.</p> <ul style="list-style-type: none"> • Documents confirming the possession of another source of family income (e.g. from commercial activities, renting an apartment) must be proved by providing relevant certificates as well as proof of payment of tax. <p>Хөрөнгийн баталгаа (доорх бичиг баримтуудаас бүрдүүлнэ):</p> <ol style="list-style-type: none"> 1. Аяллын чек, 2. Банкны зээлийн картанд байгаа үлдэгдэл мөнгөний хэмжээг баталсан банкны тодорхойлолт (Монгол, Польш эсвэл өөр улсад байрладаг аливаа нэгэн банк байж болно), 3. Польш Улс, Европын холбооны орнуудын банк эсвэл Бүгд Найрамдах Польш Улс, Европын Холбооны нутаг дэвсгэрт байрлах хадгаламж зээлийн хоршоо, нийгэмлэгт хадгаламжтайгаа батлах тодорхойлолт (Монголын банкууд дахь хадгаламжийн дансны тодорхойлолтыг хүлээн авахгүй), 4. Монголын болон гадаадын тэтгэлэг авсаныг тодорхойлсон баримт, 5. Виз мэдүүлэгчийн сарын цалингийн хэмжээг тодорхойлсон ажил олгогчийн албан бичиг <p>2,3, 5-р зүйлд заасан баримт бичиг нь виз мэдүүлэхээс өмнө нэг сарын дотор хүчинтэй байх ёстой.</p> <p>Санхүүгийн хувьд эцэг эхээсээ хараат байдалд байдаг насанд хүрээгүй болон насанд хүрсэн иргэн (хэрвээ та энэ асуудалтай холбоотой бол) бүрдүүлэх бичиг баримт. Эцэг эхээс гаргасан ивээн тэтгэгчийн бичиг, 1-5-р зүйлд заасан санхүүгийн эх үүсвэрээ баталсан баримт бичиг. Ивээн тэтгэгчийн бичигт виз хүсэгчийн аяллын, байрны гэх мэт бүх зардлыг эцэг эх хариуцахыг тусгасан байна. Хэрвээ виз хүсэгчийн төрсний гэрчилгээнд ивээн тэтгэгч эцэг эхийн бүртгэл</p>			
--	--	--	--

	<p>байхгүй байгаа тохиолдолд виз хүсэгч тухайн хүмүүстэй гэр бүлийн хэлхээ холбоог нотлох улсын бүртгэлийн гэрчилгээг /Монгол хэлээр бичсэн/, Гадаад хэргийн яамнаас баталгаажуулан, польш эсвэл англи хэлэнд хөрвүүлэн бүрдүүлнэ.</p> <p>Консулаас зөвшөөрөл авсан тохиолдолд л гуравдагч этгээдийн ивээн тэтгэх хүсэлтийг хүлээн зөвшөөрнө. Ивээн тэтгэгчийн бичгийг нотариатаар гэрчлүүлж, Монгол Улсын Гадаад хэргийн яамаар баталгаажуулсан байх ёстой.</p> <p>Нэмэлтээр бүрдүүлэх шаардлагатай бичиг баримт:</p> <ul style="list-style-type: none"> • Эцэг эхийн ажлын байрны тодорхойлолтыг албан бланкан дээр үйлдэж, зохих ёсоор гарын үсэг зурж, тамга дарж, сарын цалингийн хэмжээг тусгасан байна. • Хэрэв эцэг эх нь тэтгэвэрт гарсан бол тэтгэвэрт гарсан эсвэл бусад тогтмол орлоготой болохыг нотлох баримт. • Гэр бүлийн орлогын өөр эх үүсвэрийг батлах баримт бичиг (жишээлбэл, арилжааны үйл ажиллагаа, орон сууц түрээслэх гэх мэт) холбогдох гэрчилгээ, татвар төлсөн баримт. 			
10.	<p>Proof of appropriate accommodation for the intended period of stay:</p> <ol style="list-style-type: none"> 1. Certificate of registration (<i>zameldowanie</i>), 2. Lease agreement, 3. Decision on the provision of the dormitory issued by the unit conducting the studies, 4. Other lending contract. <p>Documents shall contain information about the cost of living.</p> <p>Польш Улсад байх нийт хугацаандаа байрлах байрны баталгаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. Оршин суух бүртгэлийн баталгаа (<i>zameldowanie</i>), 2. Түрээсийн гэрээ, 3. Сургалт зохион байгуулагчаас дотуур байраар хангах тухай шийдвэр, 4. Бусад зээлийн гэрээ. <p>Баримт бичигт амьжиргааны өртгийн талаархи мэдээлэл багтсан байх ёстой.</p>			
11.	<p>Letter from university or school in Mongolia confirming student's status and purpose of travelling as well as copy of student ID card (only if applicable)</p> <p>Одоо Монголд суралцаж буй их сургууль, ерөнхий боловсролын сургуулиас гаргасан албан бичиг. Албан бичигт оюутан, сурагчийн статусыг баталгаажуулсан байна. Оюутан, сурагчийн үнэмлэхний (хэрвээ энэ тантай холбоотой бол) хуулбарыг хавсаргана.</p>			
12.	<p>Flight Reservation (reservation only)</p> <p>Нислэгийн захиалга (зөвхөн захиалгын хуудас)</p>			
13.	<p>Minors travelling alone or with one parent:</p> <ol style="list-style-type: none"> 1. Notarized birth certificate legalized by MFA, 2. Notarized certificate of permission to travel from both parents or legal guardians legalized by MFA, • In case the parents are not in Mongolia – certificate attested by the relevant authorities in the country of residence, 3. Notarized death certificate in case of death of a parent, 4. In case the parents are divorced and one of the parents lost custody of the child – notarized court verdict legalized by MFA. <p>Ганцаараа эсвэл эцэг эхийн хамт аялаж яваа насанд хүрээгүй хүүхэд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ГХЯ-наас баталгаажуулсан төрсний гэрчилгээ, 2. ГХЯ-наас баталгаажуулсан, нотариатаар гэрчлүүлсэн, эцэг эхийн, хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрөл, • Эцэг эх нь Монголд байхгүй тохиолдолд оршин суугаа улсын холбогдох байгууллагуудаар баталгаажуулсан зөвшөөрөл, 			

	3. Эцэг эхийн аль нэг эсвэл хоёулаа нас барсан тохиолдолд нас барсны тухай нотариатаар гэрчлүүлсэн, ГХЯ-аас баталгаажуулсан гэрчилгээ, 4. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь хүүхэд асрамжлах эрхээ алдсан тохиолдолд – ГХЯ-наас баталгаажуулсан, нотариатаар гэрчлүүлсэн шүүхийн тогтоол.			
14.	Additional notes: optional documents. Applicants are allowed to submit additional documents that they consider useful to explain and/or justify the trip. Нэмэлт мэдээлэл: нэмэлт баримт бичиг. Виз хүсэгч аяллын зорилгоо тайлбарлах / эсвэл батлах нэмэлт баримт бичиг хавсаргаж болно.			

Note: The Embassy/Consulate General of the Republic of Poland reserves **the right to request additional information/documentation** and, if deemed necessary, **to interview the applicant in person.**

Анхаарах зүйл: Бүгд Найрамдах Польш Улсын Элчин сайдын яам/Ерөнхий Консулын Газрын зүгээс **нэмэлт бичиг баримт шаардах** болон шаардлагатай гэж үзвэл **виз мэдүүлэгчтэй ярилцлага хийх эрхтэй болно.**

The consul is entitled to assess whether the applicant's **knowledge of the language** in which the course/training is to take place **will allow him or her to undertake the education.**

Виз мэдүүлэгчийн **хэлний мэдлэгийн түвшин дамжаа/сургалтад хамрагдахад хангалттай сайн эсэхэд** Консул үнэлгээ өгөх эрхтэй болно.

To be completed by the Inquiry Officer:

Визний мэдүүлэг хүлээн авагч бөглөнө:

1. The applicant has confirmed that s/he has **no other documents to submit.**

Виз мэдүүлэгч **нэмж бүрдүүлэх өөр бичиг баримт байхгүй** болохоо баталсан болно.

2. The applicant has submitted the supporting documents listed above. I have advised him/her that **failure to submit all necessary documents** may result in the application being **refused**. The applicant has chosen to proceed with the application.

Дээрх бичиг баримтууд нь виз мэдүүлэгчийн бүрдүүлж өгсөн бичиг баримтууд мөн болно. **Бичиг баримт дутуу бүрдүүлэх тохиолдолд** визний мэдүүлэг хүлээж авахгүй болохыг виз мэдүүлэгчид анхааруулсан болно. Виз мэдүүлэгч энэхүү мэдээлэлтэй танилцсан ба виз мэдүүлэх үйл явцыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн болно.

3. I have advised the applicant that **the Embassy/Consulate does not give back the documents** that are submitted with the application and that the applicant is advised to make an appropriate amount of copies of documents that she/he might need in future.

Элчин сайдын яам/Консулын газар визний мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтуудыг виз мэдүүлэгчид буцааж олгохгүй ба ирээдүйд өөрт нь хэрэгтэй байж болох бичиг баримтыг зохих хэмжээгээр нь хуулбарлаж авахыг виз мэдүүлэгчид зөвлөсөн болно.

Visa fee Визний хураамж		Courier fee (if any) Шуудангийн үйлчилгээний хураамж (хэрвээ байгаа бол)	
Service fee Үйлчилгээний хураамж		Other fees Бусад хураамж	

Name & signature of Inquiry Officer

Визний мэдүүлэг хүлээн авагчийн нэр, гарын үсэг

Date Огноо

Applicant's signature

Виз мэдүүлэгчийн гарын үсэг